




16th Story

Шавь нарттайгаа сүүлийн зоог барьсан нь

Passover

Шавь нартайгаа сүүлийн зоог барьсан нь!

– 16th Story –



Өгүүлэгч Есүс олон гайхамшгийг үйлдэв. Өвдсөн хүмүүсийг эдгээж, хараагүй хүмүүсийг хараатай болгож өгсөн. Сонсож чадахгүй хүнийг сонсдог болгож, алхаж чаддаггүй хүнийг алхуулсан. Есүс өөрийгөө Бурханы хүү гэдгээ мэдүүлсэн юм. Есүс эдгээр зүйлсийг үйлдэх хооронд олон хүн Есүсийг дагах болсон бөгөөд Есүст хайртай болсон. Гэвч фарисайчууд, хуулийн багш нар дургүй байв. Тэгээд Есүсийг хөнөөх арга үргэлжлүүлэн хайж байсан. Нэгэн өдрийн орой Есүсийн шавь нарын нэг нь маш аймшигтай зүйл хийсэн юм. Есүсийг алах гэж байсан ахлагчид дээр нууцаар очсон байхгүй юу. Тэгээд өөрийгөө тусалбал хэдэн мөнгөн зоос өгч чадахыг асуухаар болов. Хэн ч мэдэхгүй харанхуй шөнөөр гарч одов.

Ахлагч 1 Чамайг сэтгэлээ өөрчилснийг мэдэж байна ...

Ахлагч 2 Тэр хүнд итгэж болохгүй гэж хэлсэн биз дээ.

Искаротын Иудас Үгүй ээ, уучлаарай. Баттай мэдэж авахыг л хүссэн

Ахлагч 1 Тэгээд юу гэж хэлмээр байна? Бид яагаад өдийд энд уулзах ёстой билээ?

Искаротын Иудас Намайг хэн болохыг мэднэ биз дээ?

Ахлагч2 Та бол Есүсийг дагагч

Искаротын Иудас Тиймээ

Ахлагч 2 Юу хүсээв?

Искаротын Иудас Хэрэв би Есүсийг та нар өгвөл та нар надад юу өгөх вэ?

Ахлагч 2 Чи хайртай багшаасаа урвана гэж үү?

Ахлагч 1 Хм... гараа өг дөө

NAR Искариотын Иудас гараа сунгахад ахлагч нар 30 мөнгөн зоос тоолж өглөө.

Ахлагч Тэгвэл, хэзээ боломжтой вэ?


Искаротын Иудас Хамгийн тохиромжтой үеийг хүлээж байгаад мэдэгдэе.

Ахлагч Хэрэв худлаа ярьвал зүгээр орхихгүй шүү

Искаротын Иудас За тангараглая.

Өгүүлэгч Исгээгүй талхны баярын эхний өдөр шавь нар нь Есүс дээр очив.

Петр Есүс танд зориулан Алгасал баярын зоогийг бэлтгэх гэсэн юм. Хаана хийвэл дээр вэ?



Есүс	Иерусалим хотод нэгэн хүн дээр оч. Түүнд “Багш «Миний цаг ойртож байна. Би танайд шавь нартайгаа Алгасал баярыг тэмдэглэнэ» гэж хэлээрэй.
Петр	за Эзэн минь, За явцгаая.
Өгүүлэгч	Шавь нар нь нөгөөх айлд очоод Есүсийн айлдсан хүнд хэлэв.
Гэрийн эзэн	Хөөх, Багш алгасал баярын зоог зооглохоор ирнэ гэж үү?
Петр	Тиймээ
Гэрийн эзэн	Тэр бол манайд хамгийн их хүндэтгэлийг хүртэх Нэгэн. Түүнтэй хамт байдаг та бүхэн ч бас.
Иохан	Үнэхээр найрсаг хүн юм.
Гэрийн эзэн	Ийшээ ирнэ үү. Өрөө бэлдээд эхнэртээ хоол бэлтгэ гэж хэлье.
Өгүүлэгч	Оройн хоол идэх цаг болох үед Есүс шавь нартайгаа хамт хоолны ширээнд суув. Хамтдаа хооллож байх үед Есүс шавь нартаа нухацтай айлдсан.
Есүс	Би үнэнээр та нарт хэлье. Та нарын нэг чинь Надаас урвана.
Шавь нар	юу гэнээ? Тоглоом биз дээ? Бидний нэгэн үү? Тэр хэн бэ?
Иохан	Би биш биз дээ, Эзэн минь?
Иаков	Би биш биз дээ, Эзэн минь
Андрей	Би биш биз дээ?
Петр	Би лав биш, Есүс ээ
Өгүүлэгч	Шавь нар нь бүгд Есүст би биш гэж хэлэв. Тэднийг хэлж дуусмагц Есүс хариулсан.
Есүс	Тавганд Надтай гар дүрэгч нь Надаас урвах болно. Хүний Хүү Өөрийнх нь тухай бичигдсэнчлэн явна. Харин Хүний Хүүг бариулах тэр хүн золгүй еэ!
Өгүүлэгч	Искаротын Иудас, тэр хооронд юу ч хэлэхгүй байснаа эцэст нь Есүсээс асуув.
Искаротын Иудас	Би биш биз дээ. Тийм биз дээ багш аа?
Есүс	Тийм ээ чи
Өгүүлэгч	Есүсийн шавь нар бүгд гайхаж айж байсан. Есүст яаж ийм зүйл болж чадах билээ? Яаж Искаротын Иудад уурлах ч үгүй байдаг билээ? Есүс талх аван залбираад хувааж шавь нартаа өгөв.
Есүс	Үүнийг ид. Энэ бол Миний бие.
Өгүүлэгч	Есүс усан үзмийн дарстай аяга авч талархан залбирсны дараа шавь нартаа өгөв.

Есүс

Үүнээс та нар бүгдээрээ ууцгаа. Энэ нь гэм нүглийн
уучлалын тулд олны төлөө урсгах гэрээний цус минь юм.
Би та нарт хэлье. Үүнээс хойш Би энэ усан үзмийн дарсыг
Эцэгийнхээ хаанчлалд та нартай шинээр уух өдрийг
хүртэл уухгүй.

Өгүүлэгч

Есүс үгээ хэлж дуусмагц, бүгд хамтдаа магтан дуулаад
Чидун уул руу явлаа.

